

**Мэдээллийг дахин хянасан огноо: 2019 оны 8-р сар (14 дэх хувилбар)
*Мэдээллийг дахин хянасан огноо: 2014 оны 4 сар

Япон Улсын Барааны стандарт ангилал:
873311

Натрийн хлоридын изотоник уусмал
Салин PL “ФУСО”

Хадгалах нөхцөл: Тасалгааны хэмд хадгална.
Хүчинтэй хугацаа: Савлагааны гадна хэсэгт тэмдэглэсэн. Хүчинтэй хугацаа дууссанаас хойш хэрэглэхийг хориглоно.
Анхааруулга: “ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ БОЛГООМЖЛОЛ” хэсгийг үзнэ үү.
Жороор олгох эм: (Анхааруулга - Зөвхөн эмчийн жор, зааврын дагуу хэрэглэнэ.)

	50 mL	100 mL
Зөвшөөрлийн дутаар	21900AMX01473	
Үндэсний эрүүл мэндийн даатгалын нөхөн төлөх жагсаалтанд орсон огноо	1988 оны 7-р сар	1987 оны 10-р сар
Япон Улсын зах зээлд анх нийлүүлж эхэлсэн огноо	2003 оны 10-р сар	1987 оны 10-р сар
Дахин үнэлсэн үр дүн	1977 оны 10-р сар	

ТОДОРХОЙЛОЛТ

1. Найрлага

Салин PL “ФУСО” нь полиэтилен туншил, хуванцар сав эсвэл хуванцар уутанд 0.9 W/V%-ийн натрийн хлорид агуулсан өнгөгүй, тунгалаг, усан тарилгын уусмал.

[Электролитийн агууламж]

Na ⁺	Cl ⁻
154.0	154.0

(mEq/L: Онолын үнэлгээ)

2. Ерөнхий шинж

Салин PL “ФУСО” нь полиэтиленд савлагдсан, сул давсархаг амттай өнгөгүй, тунгалаг усан тарилгын уусмал юм.

pH: 4.5-аас 8.0

ХЭРЭГЛЭХ ЗААЛТ

- Эсийн гаднах шингэний дутагдал, натрийн дутагдал мөн хлорын дутагдлын үед хэрэглэнэ.
- Тарилгын эмийг уусгах болон шингэлэхэд хэрэглэнэ.
- Арьс, шархны гадаргуу болон салст бүрхэвчийг угаах, түрхэх мөн түүнчлэн ам зайлах, утлага болон цацлага хийхээс гадна гуурсан хоолойн салст бүрхэвчийг угаах, өтгөн цэрийг гадагшлуулахад хэрэглэнэ.
- Эмнэлгийн багаж хэрэгслийн цэвэрлэгэнд хэрэглэнэ.

ТУН БА ХЭРЭГЛЭХ АРГА

Тарилга

- Ердийн тун нь арьсан доор, хураагуур судас эсвэл хураагуур судсаар шингэн сэлбэх ээргээс хамааран 20-1000мл байна. Эмчлүүлэгчийн нас болон шинж тэмдгийг харгалзан тунг тохируулна.
- Тарилгын эмийн бүтээгдэхүүнийг уусгах, шингэлэхийн тулд зохистой хэмжээгээр авч хэрэглэнэ.

Гадуур хэрэглэх

- Арьс, шархны гадаргуу болон салст бүрхэвчийг угаах, түрхэхээр хэрэглэнэ.
- Хоолой зайлах, утлага болон цацлагад хэрэглэнэ.

Бусад

Эмнэлгийн багажуудыг цэвэрлэхэд хэрэглэнэ.

БОЛГООМЖЛОЛ

1. Болгоомжтой хэрэглээ. Эмийг дараах эмчлүүлэгчдэд болгоомжтой хэрэглэнэ.

- Зүрх эсвэл цусны эргэлтийн тогтолцооны үйл ажиллагааны алдагдалтай эмчлүүлэгчид. [Цусны эргэлтийн хэмжээг нэмэгдүүлэх эрсдэлтэй бөгөөд энэ нь зүрхэнд ачаалал өгч, шинж тэмдгийг улам дордуулж болно.]
- Бөөрний дутагдалтай эмчлүүлэгчид [Ус, натри хлоридын тун хэтрэх нь амархан бөгөөд энэ нь шинж тэмдгүүдийг хүндрүүлж болно.]

2. Гаж нөлөө

Энэ бүтээгдэхүүний гаж нөлөөний тохиолдлыг нарийвчлан тодорхойлсон судалгаа хийгдээгүй.

Хэрэв ямар нэгэн гаж нөлөө ажиглагдвал эмийн хэрэглээг зогсоох зэрэг зохих арга хэмжээг авах хэрэгтэй.

	Тохиолдол тодорхойгүй
Их хэмжээгээр болон хурдан хэрэглэх	Их хэмжээний тунг хурдан хэрэглэх нь ийлдэс дэх электролитийн хэвийн бус байдал, зүрхний дутагдал, хаван, ацидозын шалтгаан болж болзошгүй.

3. Өндөр настны хэрэглээ

Өндөр настай эмчлүүлэгчдийн физиологийн үйл ажиллагаа буурсан байдаг тул тунг аажмаар, болгоомжтой бууруулах хэрэгтэй.

4. Хэрэглээтэй холбоотой болгоомжлол

- Хэрэглэхийн өмнөх анхаарах зүйл.** Тарилгыг шингэлэх, уусгах бодис болгон ашиглахдаа Салин тохиромжтой эсэхийг шалгаарай.
- Хэрэглэхийн өмнөх болгоомжлол.**
 - Эмийг хэрэглэхдээ халдвараас урьдчилан сэргийлэхэд анхаарах хэрэгтэй (Эмчлүүлэгчийн арьс болон багаж хэрэгслийг халдваргүйжүүлнэ).
 - Хэрэглэхийг өмнө биеийн хэмний хэмжээнд хүртэл бүлээсгэх хэрэгтэй.
 - Савлагааг нээсэн даруйд шууд хэрэглэнэ, үлдэгдэл шингэнийг дахин хэрэглэхийг хориглоно.
- Арьсан доорх тарилга.** Мэдрэл болон зөөлөн эдэд ямар нэгэн нөлөө үзүүлэхээс сэргийлэн арьсан доор тарихаас өмнө дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. .
 - Мэдрэлийн судал дайрахаас сэргийлж тарих.
 - Тарилгыг давтан хэрэглэх шаардлага гарвал тарилгын талбайг өөрчлөх хэрэгтэй, жишээлбэл, баруун ба зүүн талд ээлжилнэ.
Нярай, бага насны хүүхдүүд, өвчтэй хүүхдүүдэд тариаг давтан хийхийг зөвлөхгүй.
 - Тарилгын зүүг хатгах үед эмчлүүлэгчдэд хүчтэй өвдөлт мэдрэгдэх эсвэл цус буцаж урсаж болно. Энэ тохиолдолд зүүг нэн даруй сугалж, тарилгын талбайг өөрчилнө.
- Судсаар тарих үед.** Тариаг судас руу аажмаар тарина.

ФАРМАКОКИНЕТИК

Натри хлорид нь цусны ийлдэс дэх органик биш бүрэлдэхүүний 90%-аас их хэсгийг бүрдүүлдэг бөгөөд эсийн гаднах шингэний осмос даралтыг хадгалах гол хүчин зүйл нь болдог^{1,2)}.

Салин нь натри хлоридын уусмал бөгөөд эсийн гаднах шингэнтэй бараг адилхан изотоник чанартай бөгөөд ус, электролитийн шингэн алдалттай эмчлүүлэгчдэд эсийн гаднах шингэний хэмжээг үр дүнтэй байлгах, цусны эргэлтийг тогтворжуулах зорилгоор хэрэглэнэ³⁾.

Энэ нь эс хордуулагч биш учир арьс болон салст бүрхэвчийг цэвэрлэх, эмийн бодисуудын уусгагч болгон ашиглах мөн өтгөн цэрийг шингэлэх, ховхлох зорилгоор амьсгалын замаар утлага болон цацлагаар хэрэглэнэ^{1,3)}.

ФИЗИК, ХИМИЙН ШИНЖ ЧАНАР

Олон улсын нэршил: Натри хлорид
Химийн нэршил: Натри хлорид
Молекулын томьёо: NaCl
Молекул жин: 58.44
Ерөнхий шинж: Өнгөгүй эсвэл цагаан талст эсвэл талстлаг нунтаг.
Усанд уусдаг, этанолд уусдаггүй. (99.5).

ХЭРЭГЛЭХ ҮЕИЙН БОЛГООМЖЛОЛ

50мл, 100мл:

- 1) Агааржуулалтын зүү шаардлагагүй. (Тарилгын хэмжээнээс хамаарч агааржуулалтын зүү шаардагдаж болно.)
- 2) Дуслаар хийх уусмалыг судсаар тасралтгүй хэрэглэх үед холбогч гуурсыг ашиглахгүй. Тасралтгүй хэрэглээнд ашиглах үед Y-төрлийн багцыг хэрэглэхийг зөвлөнө.
- 3) Хэрэв уусмал уутнаас гоожсон эсвэл булингартсан байвал бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй.
- 4) Бүрхэвч (резин таглааг бохирдуулахаас хамгаалсан бүрхэвч) хуулагдсан байвал бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй.
- 5) Бүтээгдэхүүний резинэн таглааг цоолохдоо зүүг тагны гадаргуунд 90 градусын эгц шулуун байрлалтай барьж аажмаар хатгана. Хэрэв зүүг налуу шугамаар тагийг хатгавал уусмалыг резинэн үйрмэгээр бохирдуулах эсвэл тарилгын нүхийг гэмтээж, уусмал гоожих шалтгаан болно.
- 6) Хэрэглэсэн уусмалын эзлэхүүнийг тооцоолоход дуслын уутанд тэмдэглэсэн хэмжүүрийг ашиглана.

САВЛАГАА

50мл: Хайрцагт, 10 ширхэг хуванцар савтай

100мл: Хайрцагт, 10 ширхэг хуванцар савтай

PL нь FUSO Pharmaceutical Industries, Ltd-ээс тусгайлан боловсруулсан полиэтилен туншлыг хэлнэ.

ИШЛЭЛҮҮД

- 1) The United States Dispensatory, 27th ed., 1050 (1973)
- 2) Martindale: The Extra Pharmacopoeia, 29 th ed., 1039 (1989)
- 3) AMA Drug Evaluations, 3rd ed. ed., 233, 65 9 (1977)

Үйлдвэрлэгч ба Түгээгч

FUSO PHARMACEUTICAL INDUSTRIES, LTD.

2-3-11, Morinomiya, Joto-ku, Osaka 536-8523, Japan